



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/824

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдсэн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд 9, 10, 11, 12 дугаар сард зарцуулах зардалд зориулан 19 910 000 төгрөгийг зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 19 910 000 төгрөг /арван есөн сая есөн зуун арван мянга/-ийг аймгийн Байгаль хамгаалах сангийн 1.1-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 21-ний өдрийн
А/824 дүгээр захирамжийн хавсралт



“ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГТ ХОГ ОТВОЛДОЖ ДАРЖ ЗАМ ГАРГАХ
АЖИЛ”-ЫН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗАРДАЛ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /110 хоног/	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1.	Хогийн цэгт ажиллах шатахууны зардал	л	2540	2700	6 858 000
2.	Хогийн цэгт ажиллах шатахууны зардал	л	2465	2800	6 902 000
2.	Тос, масло	багц	4	610 000	2 440 000
3.	Сэлбэг, хэрэгсэл	багц	4	724 000	2 896 000
4.	Хөдөлмөр хамгааллын зардал	Хүн/өдөр	110	4000	440 000
5.	Жолоочид урамшуулал, хоолны зардал	Хүн/өдөр	110	3400	374 000
Нийт					19 910 000

-oOo-